

## 8

## ХӨГЖЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ШИНЖИЛГЭЭ

Ш.Дэнсмаа

Аливаа хөгжил нь тухайн нийгмийн нийтлэг хүсэл эрмэлзлэлийн тусгал болох үнэт зүйлс хийгээд үнэлэмжийг сайжруулах үйл явц юм. Хөгжлийн үйл явц шугаман байх боломжгүй бөгөөд маш олон төрлийн хүчин зүйлс харилцан адилгүй байдлаар нөлөөлөх тул хөгжлийн түвшинг хэмжих хэмжүүр ч нэг хэвийн байдаггүй. Тухайлбал, хөгжлийн үнэт чанар гэдэг ойлголтыг хүний амьдралын наад захын нөхцлийг хангах буюу үндсэн хэрэгцээг хангах чадвар, өөрийгөө хүндлэх буюу хүн шиг амьдрах нөхцөл, чөлөөт байдал буюу сонгох эрх гэсэн үзүүлэлтээр хэмжсэн барууны судлаачдын үзэл баримтлал нэлээд үнэ цэнэтэйд тооцогддог. Гэхдээ хөгжлийн тухай ойлголт, баримжаа, төсөөлөл, үнэлэмж байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж ирсэн бөгөөд энэ нь хүн төрөлхтний амьдрал болоод орчноо танин мэдэх түвшин, арга хэлбэр, хэв маягтай салшгүй холбоотой юм. Аливаа зүйл, түүний дотор үзэл санаа өөрийн орон цаг, орчин нөхцөлтэй<sup>8</sup>.

Улс орныг хөгжүүлэх аливаа бодлогын үндэслэл нь хөгжлийн тодорхой онол, үзэл баримтлал дээр суурилсан байдаг. Хөгжлийн тухай орчин үеийн онол, үзэл баримтлалуудыг ерөнхийд нь дараах байдлаар хоёр ангилж болно.

- 1) Өсөлтөд тулгуурласан (*Growth-centered Development*)
- 2) Хүн төвтэй (*Human-centered Development*)

Өсөлтөд тулгуурласан болон хүн төвтэй хөгжлийн гэсэн чиг хандлагууд нь Дэлхийн банкны "Дэлхийн хөгжлийн илтгэл", НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газрын "Хүний хөгжлийн илтгэл" зэрэг баримт бичгүүдэд тусгалаа олсон байдаг. Дэлхийн банк нь гол төлөв **өсөлтөд төвлөрсөн хөгжлийг** голлон анхаардаг бол НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр<sup>9</sup> нь **хүн төвтэй хөгжилд** илүү анхаарч "Хүний хөгжлийн илтгэл"-дээ энэ талаар тусгасан байдаг нь Дэлхийн банкны "Дэлхийн хөгжлийн илтгэл"-ээс ялгагдах онцлог болдог.

<sup>8</sup> А.Цанжид "Хөгжлийн стратегийн талаар эргэцүүлэх нь" УБ 2008 х.9


<sup>9</sup> НҮБХХ-ийн хирээнд 1990 оноос жил бүр Дэлхийн Хүний хөгжлийн илтгэл, 1992 оноос улс орнууд Үндэсний Хүний хөгжлийн илтгэлийг бэлтгэн гаргах болсон. Монгол улс 1997, 2000, 2003, 2007 онуудад НҮБ-ын дэмжлэг, аргачлалын дагуу Хүний хөгжлийн Үндэсний илтгэлээ бэлтгэн, нийтэд танилцуулжээ.

Хөгжлийн талаарх үндсэн хоёр онолын гол санааг ямар нэгэн хэмжээгээр агуулсан гурав дахь онол нь эдийн засаг, нийгмийн хөгжил, байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалал болон сайн засаглалыг бий болгох асуудлуудыг цогц байдлаар уялдаа холбоонд нь авч үздэг **тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан онол** юм. Өөрөөр хэлбэл, урт хугацааны тогтвортой өсөлт нь зөвхөн эдийн засгийн асуудал бус хүрээлэн буй орчин болон нийгэм, эдийн засгийн төлөв байдлыг бүхэлд нь хамарч байх ёстой. Иймээс тогтвортой хөгжлийн цөм нь ХҮН байх<sup>10</sup> бөгөөд хүн төрөлхтөн байгальтайгаа зохицон үр бүтээлтэй, эрүүл, сайхан амьдрах боломжийг хангах нь хөгжлийн шинэ загварын гол агуулга хийгээд мөн чанар юм.

Дэлхийн банкнаас 2000 онд хэвлүүлсэн “Эдийн засгийн өсөлтийн цаана” бүтээлд “Тогтвортой хөгжлийн ойлголт, тодорхойлолтыг байнга эргэн харж, нягтлан тунгааж, нарийвчлан тодорхойлж байгаа ч ... нийгмийн шудрага байдал бол сайн сайхан аж төрөх боломжийн тэгш байдал юм. Хүмүүс, үе үеийн хоорондын харилцаа нь хамгийн багадаа гурван талтай бөгөөд эдгээр нь эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин болно. Эдгээр гурван зорилгын аль алиных нь тэнцвэрийг хангаж чадсан хөгжил л урт хугацаанд тогтвортой хадгалагдана. Зөвхөн аль нэгд нь анхаарал хандуулах нь эдийн засгийн өсөлт төдийгүй хөгжлийн үйл явцад хортойгоор нөлөөлөх болно” гэжээ.

**ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ** гэдэг нь байгаль, нийгмийн аль ч түвшний, ямар ч төвөгтэй системийн хөгжлийг хангахдаа түүний аюулгүй байдлыг хадгалж, өнөөгийн болон хойч үеийнхээ “амьдралын чанар”-ыг хэвийн түвшинд байлгах үйл явц хэмээн тодорхойлж болох юм.

Тогтвортой хөгжлийн хэмжүүрийг НҮБ-ын түвшинд 128 шалгуур үзүүлэлтээр тодорхойлох санал болгосон хэдий ч 2001 онд шинэчилж, улс орны тогтвортой хөгжлийг хэмжихэд эдийн засгийн 14, нийгмийн 19, байгаль орчны 19, зохион байгуулалтын 6, нийт 58 үзүүлэлтийн системийг түгээмэл ашиглаж байна.



<sup>10</sup> С.Будням, Б.Батхүү “XXI зууны босгон дээрх менежмент” Бис нутгийн тогтвортой хөгжил, мэдээллийн технологи – 2002 Ховд 2002 х.10-11

**Тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүд**

	Эдийн засаг	Нийгэм	Байгаль орчин	Зохион байгуулалт	Бүгд
НУБ/ ТХХ	14	19	19	6	58
МХЗ	3	10	10	-	23
Монгол улс	17	19	19	3	58

Сүүлийн жилүүдэд судлаачид тодорхой улс орон, бүс болон орон нутгийн хөгжлийн түвшинг тодорхойлох, шалгуур үзүүлэлтүүдийг сонгон авах, тэдгээрийг тооцох аргачлалыг боловсруулах, хөгжлийн нэгдсэн хэмжүүр тогтоох гэсэн оролдлогыг олонтаа хийсээр байна. Тухайлбал, Нэг хүнд ногдох бодит ДНБ-ий хэмжээ, Хүний хөгжлийн индекс, Амьдралын бодит чанарын индекс, Тэгш байдлын индекс, Хөгжлийн үзүүлэлтүүдийн нэгдсэн индекс, Ертөнцийн аз жаргалын индекс, Тогтвортой хөгжлийн индекс зэрэг олон тооцооны үзүүлэлтийг дурдаж болно.

Эдгээрийг тооцоход хамгийн түгээмэл ашигладаг статистик үзүүлэлтүүдийг сонгон авч, бид аймгуудын хөгжлийн рейтинг тогтоох оролдлого хийлээ.

- Хөгжлийн ерөнхий индекс буюу хөгжлийн рейтинг

$$I_{Dev} = \sqrt[n]{J_1 \times J_2 \times \dots \times J_n}$$

- Тухайн үзүүлэлтийн индекс -  $J_i$


$$J_i = \frac{Y_i}{Y_{max}}$$

$Y_i$  – тухайн үзүүлэлтийн утга


$Y_{max}$  – Тухайн үзүүлэлтийн хамгийн их утга

Монгол улсын эдийн засаг сүүлийн 8 жилд дунджаар 1.34 хувийн өсөлттэй байна.

**Үзүүлэлтийн өөрчлөлт**



**Үзүүлэлтийн өөрчлөлт**



Эдийн засгийн бүсүүдээр ДНБ-ий зарим үзүүлэлтийг харьцуулан үзэхэд харилцан адилгүй дүр зураг харагдаж байна.

*ДНБ-ий үзүүлэлтүүд, эдийн засгийн бүсүүдээр, 2002-2009 он*

	ДНБ-д эзлэх хувийн жин	ДНБ-ий жилийн дундаж өсөлт	I хүнд ноогдох ДНБ, мян төг	ДНБ-д салбарын эзлэх хувь		
				ХАА	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ
<b>Нийт</b>	<b>100.0%</b>	<b>1.34</b>	<b>1794.0</b>	<b>20.80</b>	<b>32.10</b>	<b>47.10</b>
Баруун	7.52%	1.32	872.4	<b>68.49</b>	2.09	29.42
Хангай	24.52%	<b>1.39</b>	2086.4	31.68	<b>52.51</b>	15.82
Төв	12.06%	1.37	1293.1	45.64	25.51	28.61
Зүүн	5.11%	1.32	1213.9	55.35	20.83	23.83
Улаанбаатар	<b>50.79%</b>	1.27	<b>2336.5</b>	0.88	29.34	<b>69.78</b>

*Эх сурвалж: ҮСХ Статистикийн эмхэтгэл 2002-2009 он*

Эдийн засаг болон нийгмийн зарим үзүүлэлтүүд бүс нутгийн хэмжээнд харилцан адилгүй байгааг дараах хүснэгтүүдээс харж болно.

**Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд, эдийн засгийн бүсүүдээр, 2002-2009 он**

	Ажилгүйдлийн түвшин, хувиар	I хүнд ноогдох орон нутгийн төсөв, 2005 оны үнээр, мян төг		I малчин өрхөд ноогдох малын тоо, хонин толгойд шилжүүлснээр
		орлого	зардал	
<b>Нийт</b>	<b>6.5</b>	<b>59952.8</b>	<b>52782.6</b>	<b>370.9</b>
Баруун бүс	5.9	37332.5	33012.8	338.9
Хангайн бүс	<b>7.2</b>	67951.4	60980.8	327.1
Төвийн бүс	6.4	<b>75124.6</b>	<b>67934.7</b>	440.1
Зүүн бүс	5.7	45844.7	39641.4	<b>509.2</b>
Улаанбаатар	6.6	60797.8	52231.6	282.5

*Нийгмийн зарим үзүүлэлтүүд, эдийн засгийн бүсүүдээр, 2002-2009 он*

	Хүн амын цэвэр өсөлт	Дундаж наслалт	Нийт хүн амд хотын хүн амын эзлэх хувийн жин	1000 хүнд ноогдох ЕБС-д суралцагчдын тоо	1000 хүнд ноогдох их эмчийн тоо
<b>Нийт</b>	14.1	65.6	60.2	208.4	2.7
Баруун бүс	<b>17.4</b>	65.0	28.9	<b>232.9</b>	1.5
Хангайн бүс	14.1	64.7	35.0	219.9	1.7
Төвийн бүс	14.0	<b>66.4</b>	42.1	214.5	2.1
Зүүн бүс	14.1	64.4	39.9	214.6	1.8
Улаанбаатар	13.1	66.3	<b>100.0</b>	188.2	<b>4.3</b>

Эдгээр үзүүлэлтүүдийн индексийг аймаг бүрээр тооцон, нэг хүнд ногдох бодит ДНБ болон хүний хөгжлийн индекс төлөөж буй зарим хүчин зүйлсийг шинжилж үзэхэд дараах хамаарал харагдаж байна.

*Хүний хөгжлийн индекс ба Нийгмийн зарим үзүүлэлтүүдийн шинжилгээ*

SUMMARY  
OUTPUT

*Regression Statistics*

Multiple R	0.967998
R Square	0.937021
Adjusted R Square	0.922202
Standard Error	0.010014
Observations	22

	<i>Coefficients</i>	<i>Standard Error</i>	<i>t Stat</i>
	0.088545	0.115262	0.768205
Хотын хүн амын эзлэх хувь, $x_1$	0.021938	0.01351	1.623809
Нэг хүнд ногдох бодит ДНБ, $x_2$	0.12961	0.014684	8.826588
Дундаж наслалт, $x_3$	0.468418	0.069891	6.702135
Боловсролын индекс, $x_4$	0.262361	0.114571	2.289952


*Хамаарлын тэгшитгэл*

$$y = 0.08855 + 0.0219x_1 + 0.1296x_2 + 0.4684x_3 + 0.2624x_4$$

Хөгжлийн ерөнхий индексийн тооцоогоор Төвийн бүс 0.4688, Хангайн бүс 0.4336, Зүүн бүс 0.4291, Баруун бүс 0.3884 байгаа ба улсын дундаж үзүүлэлт 0.4212 гарчээ.

Эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн түвшинг илэрхийлэх боломжтой цөөн үзүүлэлтүүдийг сонгон аймгуудын хөгжлийн нэгдсэн рейтингийг тооцож үзэхэд Орхон аймаг 0.6013 оноогоор тэргүүлж, Баянхонгор аймаг (0.3076) сүүлийн байранд орсон байна.

Хөгжлийн рейтинг



### ДУГНЭЛТ

- Хөгжлийн түвшинг бодитой тодорхойлж чадахуйц олон төрлийн шалгуур үзүүлэлтүүдийг зөв сонгон авч, холбогдох тооцоо судалгааг хийх шаардлагатай бөгөөд ингэснээр орон нутгийн хөгжлийн түвшинг үнэлж, цаашид дэмжлэг үзүүлэх бодлогын үндэслэлийг оновчтой гаргах боломжтой.
- Хөгжлийн ерөнхий индекс буюу рейтингийг тооцоход Төв ба Хангай бүсийн хөгжил сайн, Зүүн ба Баруун бүсийн хөгжил доогуур байна. Рейтингийн нэгдсэн дүнгээр Орхон аймаг 0.6013 –р тэргүүлж байгаа бол Баянхонгор аймаг 0.3076 –р сүүлийн байр эзэлжээ.
- Нийт хүн амд хотын оршин суугчдын тоо 1 нэгжээр нэмэгдэхэд Хүний хөгжлийн индекс 0.02 нэгжээр өснө.
- Нэг хүнд ноогдох бодит ДНБ 1 нэгжээр нэмэгдэхэд 0.13 нэгжээр өснө.
- Хүн амын дундаж наслалт 1 нэгжээр нэмэгдэхэд Хүний хөгжлийн индекс 0.47 нэгжээр өснө.
- Боловсролын индекс 1 нэгжээр Хүний хөгжлийн индекс 0.26 нэгжээр өснө.

### Ном зүй.

1. Будням.С, Батхүү.Б “ХХI зууны босгон дээрх менежмент” Бүс нутгийн тогтвортой хөгжил, мэдээллийн технологи – 2002 Ховд 2002
2. Даваасүрэн.С Хөгжлийн экономикс УБ 2002
3. Очирбат.П нар “Тогтвортой хөгжлийн боловсрол” УБ 2004
4. ҮСХ Статистикийн эмхэтгэл 2002, 2005, 2009 он
5. Цанжид.А “Хөгжлийн стратегийн талаар эргэцүүлэх нь” УБ 2008
6. Цэдэндамба. нар “Бүс нутгийн хөгжлийн түвшний үнэлгээ” УБ 2009
7. Чадавхи-21, ҮСГ “Тогтвортой хөгжлийн үзүүлэлт Монголд” УБ 2003
8. Энхбайгаль.Б “Эдийн засгийн хөгжлийн шугаман биш загвар боловсруулах нь” (Мэдлэгт түшиглэсэн эдийн засаг) УБ 2006